



**НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 817

Улаанбаатар хот

**Г.Мөнхдэмбэрэлийг ажилд томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолыг тус тус ҮНДЭСЛЭН тушаах нь:

1. Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Дэмбэрэлсамбуугийн Эрдэнэбилэгийг ажилд орох хүртэл жирэмсний амралтын хугацаанд 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн Ганзоригийн Мөнхдэмбэрэлийг томилон ажиллуулсугай.

2. Г.Мөнхдэмбэрэлийн сарын үндсэн цалинг төрийн захиргааны ангиллын ТЗ-5 дугаар зэрэглэлд хамааруулан 509.948 /таван зуун есөн мянга есөн зуун дөчин найман/ төгрөгөөр цалинжуулж, хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлийн хамт олгохыг нягтлан бодогч /Б.Батбаатар/-т зөвшөөрсүгэй.

3. Г.Мөнхдэмбэрэлд байгууллагын дотоод журам, ажил үүргийн хуваарийг танилцуулахыг Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Г.Гантүшиг/-т даалгасугай.

ДАРГА



П.БАТХҮЛЭГ

1150500035